



ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.21 № 01/31 ДУА-2017/108/СТА -ТШ/З

Г Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Хулд сумын Цэцэрлэгийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Хоолны материалын тооцоог цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодоогүй, 28,941,430.00 төгрөгийг зардалд тайлагнаж, хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад /1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг/ заасныг тус тус зөрчсөн байна.

- Нийт 2,500,00.00 төгрөгийн бичиг хэргийн материал /принтерийн хор, бичгийн цаас/-ыг их хэмжээгээр худалдан авч, зардалд тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хотлоогүй/, 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй,

000000066

зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулжээ. Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Хүнсний бүтээгдэхүүнийг зарцуулахдаа холбогдох стандарт, журмын дагуу насны ангиллаар хүүхдийн хоногийн хоолны хэрэгцээг хангах, жишиг нормоор тооцоог бодож зарцуулалтанд хяналт тавьж хэвших,
2. Бичиг хэргийн зардлыг бодитоор төлөвлөж, зарцуулах, хяналт тавих,
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 05-ны дотор ирүүлэхийг Хулд сумын Цэцэрлэгийн эрхлэгч Ц.Туяацэцэг, нягтлан бодогч Э.Хонгорзул нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ

A handwritten signature in black ink, appearing to read "Shinghee".

Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ

A handwritten signature in blue ink, appearing to read "Erxleb".

Ц.ТУЯАЦЭЦЭГ

НЯГТЛАН БОДОГЧ

A handwritten signature in blue ink, appearing to read "Nyagtlan Bodogch".

Э.ХОНГОРЗУЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.